



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/142

Мандалговь

Зохион байгуулалтын арга хэмжээ  
авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6."а", Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Засгийн газрын 2021 оны 45, 91 дүгээр тогтоол, Улсын Онцгой комиссын 2021 оны 02 дугаар тогтоол, аймгийн Онцгой комиссын 2021 оны 11 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор аймгийн хэмжээнд гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт 2021 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 06.00 цагаас 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 00.00 цаг хүртэл хугацаанд шилжүүлж Эрдэнэдалай сумаас орох, гарах хөдөлгөөнийг хязгаарлаж хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газар (М.Адъяабаатар), Цагдаагийн газар (Г.Наранбаатар), Эрдэнэдалай сумын Засаг дарга (Б.Лхагвамандал) нарт үүрэг болгосугай.

2. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд 18 градусаас дээш агууламжтай согтууруулах ундааны зүйлс худалдан борлуулах, түүгээр үйлчлэхийг 2021 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 06.00 цагаас 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 00.00 цаг хүртэл хугацаанд хориглож хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Г.Наранбаатар), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Төрийн байгууллагуудыг ажлын тусгай горимоор ажиллуулах цагийн хуваарийг баталж мөрдүүлэн ажиллахыг сумдын Засаг дарга, байгууллагын дарга, удирдлагуудад үүрэг болгосугай.

4. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн сургалтын үйл ажиллагааг 2021 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 06.00 цагаас 2021 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 00.00 цаг хүртэл хязгаарласугай.

5. Худалдаа үйлчилгээ, хүнсний дэлгүүрүүдийн ажиллах цагийн хуваарийг 09.00 цагаас 21.00 цагийн хооронд байхаар тогтоож хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), Цагдаагийн газар (Г.Наранбаатар) нарт даалгасугай.

6. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан албан байгууллага, орон сууцны орц, хүүхдийн тоглоомын талбай зэрэг халдвар тархах эрсдэл бүхий орчны ариутгал халдваргүйтгэл хийж гүйцэтгэхийг тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, байгууллагуудын удирдлагууд, Эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат) нарт тус тус үүрэг болгосугай.

7. Уул уурхайн компаниудын ажилчдын ээлж солих ажлыг 2021 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр хүртэл хязгаарлаж, тээвэрлэлтийг батлагдсан маршрутын дагуу халдвар хамгааллын дэглэмийг баримтлуулан гүйцэтгүүлж хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Г.Наранбаатар), Мэргэжлийн хяналтын газар (Ш.Төрбат), сумдын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

8. Оршуулга, буяны ажиллагаанд оролцсон иргэдээс халдвар тархах эрсдэл өндөр байгаа тул оролцох хүний тоонд хязгаарлалт тогтоож зохион байгуулах талаар иргэдэд

481210391

заавар, зөвлөмж өгч хяналт тавьж ажиллахыг Онцгой байдлын газар (М.Адъяабаатар)-т үүрэг болгосугай.

9. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд 15 суманд ажиллаж буй шалган нэвтрүүлэх хяналтын цэгүүдээр нэвтэрч байгаа автомашин, иргэдэд тавих хяналт, шалгалтыг эрчимжүүлж, зайлшгүй шаардлагаар голомтын бүс нутгаас нэвтэрч байгаа болон Өмнөговь аймгаас ирж буй иргэдийн PCR шинжилгээний хариуг сайтар нягтлан шалгаж, түргэвчилсэн шинжилгээнд хамруулан нэвтрүүлж, тусгаарлан ажиглах байранд авч 7 хоног хяналт тавьж, шинжилгээний дүнг үндэслэн гэрийн ажиглалтад шилжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Эрүүл мэндийн газар (Б.Алтантөгс), сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

10. Хот хоорондын зорчигч тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг аймгийн Онцгой комиссын зөвшөөрлөөр хязгаарлаж, дамжин өнгөрч буй тээврийн хэрэгслийг зогсоохгүй өнгөрүүлэхээр зохицуулж хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (Г.Наранбаатар)-т үүрэг болгосугай.

11. Ус, цаг уурын хяналт шинжилгээний салбарын үйл ажиллагааг дээрх хугацаанд тасралтгүй явуулахыг Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн дарга (Я.Мажаасүрэн)-д үүрэг болгосугай.

12. Хөл хорио тогтоосон хууль тогтоомжийг мөрдөж, онцын шаардлагагүй бол гэрээсээ гарахгүй байж, мэргэжлийн байгууллагуудын зөвлөмжийг хэрэгжүүлэн, халдвар, хамгааллын дэглэмийг баримтлахыг аймгийн нийт иргэдэд уриалсугай.

13. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (М.Анхбаяр)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ